



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/274

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2018 оны “Жагсаалт батлах тухай” 388 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.1.2.6-д (сургууль цэцэрлэгийн барилгын их засвар) (Өвөрхангай, Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан сум)-д батлагдсан 250.000.000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100601

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дугаар
сарын 30 өдрийн 1721 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН СПОРТЫН САЙД
ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ИХ
ЗАСВАР /ӨВӨРХАНГАЙ, ХУЖИРТ, ЗҮҮНБАЯН-УЛААН, БАТ-ӨЛЗИЙ СУМ/
ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ

д/д	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /төгрөгөөр/
1	Хужирт сумын ЕБСургууль	90 000 000
2	Бат-Өлзий сумын ЕБСургууль	110 000 000
3	Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэг	50 000 000
	Нийт дүн	250 000 000

-oOo-